



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 59,900,000.00 (тавин есөн сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 20,798,609.00 (хорин сая долоон зуун ерэн найман мянга зургаан зуун есөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000375

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн
 187 дугаар тогтоолын хавсралт

МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПИАС МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
1	Ниссан Теана, 07-14 УНУ, 1N4A3NRGSC77054, Суудлын автомашин	2016/2016	91820	59,900,000.00	20,798,609.00	39,101,391.00
НИЙТ ДҮН				59,900,000.00	20,798,609.00	39,101,391.00
				(тавин есөн сая есөн зуун мянган)	(хорин сая долоон зуун ерэн найман мянга зургаан зуун есөн)	(гучин есөн сая нэг зуун нэг мянга гурван зуун ерэн нэгэн)